


“Шавардлага ба дотор заслын ажил”

Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн чухал цэгүүд

Машин ба багажууд дээр ажиллаж байгаа үеийн анхааруулга.


(1) Хөдөлгөөнт кран ажиллуулах тусгай зөвшөөрлүүд



- Хөдөлгөөнт краныг зөвхөн мэргэшсэн хүн ажиллуулна!
- Хөдөлгөөнт крантай ажиллах үед, операторууд кранаар ачаа өргөхөд мэргэшсэн эсэхийг шалгаарай.

	Үнэмлэх	Ур чадварын сургалт	Тусгай боловсрол
5 тонн юмуу түүнээс илүү өргөх даацтай хөдөлгөөнт краныг ажиллуулах	○		
1 тонн юмуу түүнээс илүү эсвэл 5 тонноос доош өргөх даацтай хөдөлгөөнт краныг ажиллуулах	○	○	
1 тонноос доош өргөх даацтай хөдөлгөөнт краныг ажиллуулах	○	○	○

(2) Кран ажиллаж байхад өргөсөн ачааны доогуур хэзээ ч бүү ор!



Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Хэрвээ материал толгой дээгүүр өнгөрвөл ажилаа зогсоогоод материалуудын байрлалыг шалга.
2. Дуут дуудлага, шүгэл, дохио, гэх мэтийг ашиглан ачаан доороос хүмүүсийг холдуулсан эсэхийг нягтлаарай.
3. Хязгаарлах хэсгийг тохируулаад ачаан доор хүмүүс орохыг чанд хориглоорой.

(3) Уяа татлагын ажлыг мэргэжлийн хүн хийж гүйцэтгэнэ



Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Зарчмын хувьд, татлагын ажиллагаа явуулах ур чадварын сургалтад хамрагдсан хүн нь бэхэлгээний ажлыг хийнэ.
2. Татлагын ажил хийхдээ тусгай зөвшөөрлийн (гэрчилгээ) авсан байна.

(4) Тийм ган татлага ашиглахыг хориглох

①




②



③




④



⑤




⑥



Дараах ган татлагыг хориглоно.

1. Илтэд няцарсан олс.
2. Голч нь хэвийн голчийн 7%-иас илүү буурсан.
3. Зангирсан олс.
4. Ширхэглэгийн 10% эсвэл түүнээс их хэсэг нь зангилаасаар хагарсан.
5. Олсны нүд гаргаж мушгисан хэсэг нь суларсан.
6. Ган хүрээний сууринд гэмтэлтэй ган татлага.


(5) Өндрийн ажлын хэрэгсэл ашиглах үеийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ



Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Шалны гишгүүрийг шалгаад зөөж байхдаа ажлын тавцанг хамгийн доод байрлал руу буулга.
2. Хүнийг унахаас хамгаалах системийг (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглэ.


(6) Өндрийн ажлын машин ашиглаж байхдаа эвгүй байрлалд бүү ажилла!



Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Өндрийн ажлын машин ашиглаж байхдаа өөрт тааламжгүй байрлалд бүү ажилла.
2. Удирдлагын хөшүүргийн байрлалыг анхааралтай шалгаад, ажлын үед хүрэхээс болгоомжил.

(7) Зүлгэх хүрдийг туршилтаар ажиллуулах ба тусгай боловсрол



Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Зүлгэх хүрдийг солих болон солих үед туршилтаар ажиллуулахыг аюулгүй байдал, эрүүл ахуйн тусгай боловсрол эзэмшсэн хүн гүйцэтгэнэ.
2. Зүлгэх хүрдийг туршилтаар ажиллуулсан эсэхээ нягтал.
 - i Ажил эхлэхээс нэг минут ба түүнээс дээш
 - ii Зүлгэх хүрдийг солих үед гурван минут ба түүнээс дээш хугацаа шаардагдана.
3. Өнгөлгөөний хайрган дээр харагдах "зөвшөөрөгдөх дээд хурд" ба "хэмжээс"-тэй тохирч байгаа эсэхийг шалга.
4. Хөвөн ажлын бээлийг хориглодог.

(8) Дискэн бутлуурын ашиглаж байгаа үед хамгаалалтын хэрэгсэл өмс!



Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Нүд хамгаалагч ашиглах.
2. Тоос шороотой ажил хийхдээ, тоосны маск ашиглах.
3. Дуу чимээ ихтэй орчинд ажиллаж байхдаа чихний бөглөөс гэх мэт чих хамгаалах төхөөрөмж өмсөөрэй.